



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар A/170.

Зуунмод

Г Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалын 2.13-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн A/607 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Дунд сургуулийн гадна талбайд гар бөмбөгийн болон сагсан бөмбөгийн талбай байгуулах /Төв, Архуст сум/” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Архуст сумын Засаг дарга (Б.Батбаатар)-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, ашиглалтад хүлээлгэн өгөх, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч мэдээллийг сар бүр Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт тайлagnаж ажиллахыг Архуст сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т, шилэн дансанд мэдээллэж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригтоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2021 оны 03-р
сарын 18-ны өдрийн 0/170 дугаар
захиралжийн хавсралт



**АРХУСТ СУМАНД 2021 ОНД ЭРХ ШИЛЖҮҮЛЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

| д/д | Төслийн нэр, хүчин чадал | Хугацаа | | Төсөвт өртөг /сая,төг/ | Санхүүжилт /сая,төг/ |
|-----|---|---------|--------|---------------------------|-------------------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| 1 | Дунд сургуулийн гадна талбайд гар бөмбөгийн болон сагсан бөмбөгийн талбай байгуулах /Төв, Архуст сум/ | 2021 | 2021 | 78.0 | 78.0 |
| | НИЙТ ДҮН | | | 78.0 | 78.0 |

_____ооо_____